



ᠮᠢ ᠠᠶᠢᠨᠢ ᠡᠡ ᠠ᠋᠋᠋᠋᠋᠋ ᠢ ᠠ᠋᠋᠋᠋᠋᠋ ᠢ ᠋᠋᠋᠋᠋᠋᠋ ᠠ᠋᠋᠋ ᠠ᠋᠋ ᠠ᠋᠋ ᠠ᠋᠋᠋ ᠠ᠋᠋᠋᠋᠋᠋ ᠢ ᠠ᠋᠋᠋᠋᠋᠋᠋

**ШИЛЭН ДАНСНЫ ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТЭД ХИЙСЭН  
НИЙЦЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН  
- ᠠᠠ-ᠢ ᠠᠠ/2016/04-ᠢ ᠠ**

Улаанбаатар	Баян-өлгий	Баянхонгор	Булган	Говь-алтай	Архангай
Говьсүмбэр	Дархан-уул	Дорноговь	Дорнод	<b>Дундговь</b>	Хэнтий
Завхан	Орхон	Өвөрхангай	Өмнөговь	Сүхбаатар	Хөвсгөл
Сэлэнгэ	Төв	Увс	Ховд		

*Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд тавих хяналт хангалтгүй байна.*

ᠮᠢ ᠠᠶᠢᠨᠢ ᠡᠡ ᠠ᠋᠋᠋᠋᠋᠋ ᠢ ᠠ᠋᠋᠋᠋᠋᠋

2016 он

## АГУУЛГА

<b>Тайланг бэлтгэсэн:</b>	Товчилсон үгс	3
Дундговь аймгийн Аудитын газар	Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй  Ерөнхий мэдээлэл	4-5
Тэргүүлэх аудитор <b>Т.ОЮУНЧИМЭГ</b>	<b>БҮЛЭГ 1. Шилэн дансны тухай хуулийн 3.1-д заасан байгууллагууд шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд бүрэн хамрагдаагүй байна.</b>	6-8
Аудитын менежер <b>Х.Наранцацрал</b>	1.1 Аймгийн хэмжээнд төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдүүдийн 98 хувь нь шилэн дансны цахим хуудсанд хамрагдсан байна.	6-7
Ахлах шинжээч <b>Д.Ихбаяр</b>	1.2 Төрийн өмчит үйлдвэрийн газрын салбар байгууллагууд төв компанидаа нэгтгэгдэж шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд мэдээлдэг байна.	7
Аудитор <b>Х.Гарам</b>	1.4 Улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт, төсөл хөтөлбөр, арга хэмжээ, ажил үйлчилгээ гүйцэтгэж байгаа аж ахуйн нэгж, байгууллагыг шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд бүртгээгүй байна.	7-8
Аудитын тайлан, дүгнэлттэй холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 70592208 дугаарын утас, 70592439 дугаарын факсаар харилцана уу.	1.5 Төрийн чиг үүрэгт хамаарах ажил, үйлчилгээг хууль тогтоомж, гэрээний үндсэн дээр гүйцэтгэгч байгууллагыг шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд бүртгээгүй байна.	8
	<b>БҮЛЭГ 2. Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг 3.1-д заасан байгууллагууд 89 хувьтай мэдээлсэн байна.</b>	8-11
	2.1 Төсөвт байгууллагууд тогтмол мэдээлэх мэдээг 92 хувьтай мэдээлсэн байна.	8-10
	2.2 Төсвийн байгууллагууд долоо хоног бүр байршуулах мэдээг 98 хувьтай мэдээлсэн байна.	10-11
<b>ХАЯГ:</b> Сайнцагаан сум 7-р баг, Нутгийн удирдлагын ордон, 209 тоот	2.5 Хуулийн 3.1.4, 3.1.5-д заасан этгээд нь 6 дугаар зүйлийн 6.9-д заасны дагуу санхүүжилт болон бусад мэдээллийг, санхүүжилтээ хүлээн авсан төсвийн байгууллагын шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд байршуулсан байна.	11
	<b>БҮЛЭГ 3. Шилэн дансны тухай хуулийн 8.1, 8.2-т заасан этгээд хяналтыг бүрэн хэрэгжүүлээгүй байна.</b>	11-12
2016 оны 12 дугаар сар	3.1 Шилэн дансны үйл ажиллагаанд тавих хөндлөнгийн хяналтыг бүх шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, иргэдийн Нийтийн Хурал хяналт тавихгүй байна.	11

3.2 Санхүүгийн хяналт, аудитын алба шилэн дансны хэрэгжилтэд хяналт тавих нөхцөл бүрдээгүй байна.	12
3.3 Өмнөх аудитаар өгөгдсөн зөвлөмж, албан шаардлагын хэрэгжилт 90 хувьтай байна.	12
Дүгнэлт	12
Зөвлөмж	13
Дээд шатны байгууллагад хүргэх санал	13
Санал тайлбар	14
Тайлангийн хавсралтууд	15-17

### ТОВЧИЛСОН ҮГС

<b>ҮАГ</b>	Үндэсний Аудитын газар
<b>ЗГТС</b>	Засгийн газрын тусгай сан
<b>ААГ</b>	Аймгийн Аудитын газар
<b>ЗДТГ</b>	Засаг даргын Тамгын газар
<b>ТЕЗ</b>	Төсвийн ерөнхийлөн захирагч
<b>ТШЗ</b>	Төсвийн шууд захирагч
<b>НББ</b>	Нягтлан бодох бүртгэл
<b>ИТХ</b>	иргэдийн Төлөөлөгчийн Хурал
<b>ТӨҮГ</b>	Төрийн өмчит үйлдвэрийн газар
<b>ОНӨААТҮГ</b>	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар
<b>ЭЭС</b>	Эмийн эргэлтийн сан
<b>ГХБХБГ</b>	Газрын харилцаа барилга, хот байгуулалтын газар
<b>ОНӨҮГ</b>	Орон нутгийн өмчит үйлдвэрийн газар
<b>ОНӨҮ</b>	Орон нутгийн өмчит үйлдвэр
<b>ТӨХК</b>	Төрийн өмчит хувьцаат компани
<b>ААТҮГ</b>	Аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
<b>БЗӨБЦТС</b>	Багануур зүүн өмнөд бүсийн цахилгаан түгээх салбар
<b>БГБХ</b>	Бүх гишүүд бүрэн хариуцлагатай

## АУДИТЫН ЗОРИЛТ, ХАМАРСАН ХҮРЭЭ, АРГА ЗҮЙ

**Аудит хийх үндэслэл, бүрэн эрх:** Шилэн дансны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, 8.3, Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.5-д заасан бүрэн эрхийн хүрээнд Дундговь аймгийн Аудитын газрын 2016 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу “Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт, үр дүн”-д аудит хийлээ.

**Аудитын зорилт:** Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт, үр дүнд аудит хийж, дүнг холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулж, олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилт чиглэгдсэн. Дээрх зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудит хийсэн.

Үүнд:

- Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1-д заасан байгууллагууд бүрэн хамрагдаж байгаа эсэх;
- Хуулийн 3 дугаар зүйлийн 3.1-д заасан байгууллагууд 6 дугаар зүйлд заасан мэдээллийг мэдээлж байгаа эсэх;
- Хуулийн 5 дугаар зүйлийн 5.3-т заасан байгууллага үүргээ бүрэн хэрэгжүүлж байгаа эсэх;
- Хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, 8.2-т заасан этгээд хяналтыг хэрэгжүүлж байгаа эсэх;
- Өмнөх аудитаар өгсөн зөвлөмж хэрэгжсэн эсэх.

“Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт, үр дүн”-д хийх нийцлийн аудитын асуудлын шинжилгээнд орсон аймагт хамааралгүй дараах асуудлуудыг тайланд тусгаагүй болно.

Үүнд:

- ✚ 1 дүгээр бүлгийн 1.3,
- ✚ 2 дугаар бүлгийн 2.3,
- ✚ 2 дугаар бүлгийн 2.4.

**Аудитын хамарсан хүрээ:** Аудитад Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-д заасан Дундговь аймгийн хэмжээнд хамрагдвал зохих нийт 189 байгууллагаас 164 байгууллага хамрагдсан. Үүнд:

Дундговь аймгийн 15 сум, аймгийн төвийн төсвийн шууд захирагчийн 113, төсвийн ерөнхийлөн захирагчийн 16, улсын төсөвт 26, ЗГТС 3, нийт 158 байгууллагын өөрийн цахим хуудас болон шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд оруулсан мэдээллийг 2016 оны батлагдсан төсвийн хуваарь, 1-10 дугаар сарын мэдээ, НББ-ийн журнал, холбогдох баримттай тулган шалгасан.

Дундговь-Ус, Нийтлэг үйлчилгээ, Дэрэн сумын Эрдэм шинжилгээ туршилт үйлчилгээний төв ОНӨААТҮГ, Дундговь аймгийн Цөм сүргийн үржлийн төв, Дундговь Нисэх буудал, Автотээврийн үндэсний төв зэрэг ТӨҮГ-ыг шилэн дансны цахим хуудсанд мэдээлэл байршуулсан эсэхийг шалгалалаа.

**Аудитын арга зүй, горим:** Аудитыг гүйцэтгэхдээ АДБОУС 100-400, 4200, Төрийн хяналт шалгалтын стандарт түүнийг хэрэгжүүлэх аргачилсан зөвлөмж, нийцлийн аудитын гарын авлагыг ашиглан, аудитын дүн, дүгнэлтэд дэмжлэг болох нотлох зүйлс цуглуулан дүгнэлт, зөвлөмж боловсруулсан.

Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан төлөвлөгөө хөтөлбөрийн дагуу аудитын дараах горимыг гүйцэтгэлээ. Үүнд:

- Аудитад хамрагдсан байгууллагуудын холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, тайлбар тодруулга авах, судалгаа хийсэн;
- Цуглуулсан мэдээ судалгаанд харьцуулалт, нөхцөл байдлын шинжилгээ хийсэн;
- Аудитад хамрагдсан байгууллагуудын шилэн дансны нэгдсэн болон өөрийн цахим хуудас, мэдээллийн самбарт байршуулсан мэдээллийг дансны хуулгын дүн, анхан шатны баримт, журналтай тулгасан.

**Аудитад ашигласан хууль, тогтоомж, шалгуур үзүүлэлт:** Дараах хууль эрхийн актыг аудитын шалгуур үзүүлэлтийн эх сурвалж болгон ашиглааа. Үүнд:

- Монгол Улсын Үндсэн хууль;
- Төсвийн тухай хууль;
- Төрийн аудитын тухай хууль;
- Шилэн дансны тухай хууль;
- Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль;
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль;
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль;
- Засгийн газрын 2016 оны 01 сарын 11 ны өдрийн 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам";
- Холбогдох бусад хууль тогтоомж, эрхийн акт, стандарт.

**Аудитын хугацаа, агаар өдөр агаар өдөр:** Аудитын гүйцэтгэлийн үе шатны ажлыг 2016 оны 10 дугаар сарын 11-ны өдрөөс эхлэн 12 дугаар сарын 06-ыг хүртэл хугацаанд тэргүүлэх аудитор Т.Оюунчимэг хянан удирдаж, аудитын менежер Х.Наранцацрал үе шатны чанарын хяналтыг хэрэгжүүлж, ахлах шинжээч Д.Ихбаяр, аудитор Х.Гарам нар хийж гүйцэтгэлээ.

**Аудитын дүн:** Аудитаар нийт 31.5 сая төгрөгийн зөрчил илрүүлж, зөрчлийг арилгуулахаар холбогдох албан тушаалтнуудад хугацаатай албан шаардлага хүргүүлсэн.

## ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Улс, орон нутгийн төсөв, улсын болон орон нутгийн өмчийн хөрөнгийг үр ашигтай захиран зарцуулах, нээлттэй, ил тод, ойлгомжтой байх, түүнд олон нийт хяналт тавих зорилгоор Монгол Улсын Их Хурлаас 2014 оны 07 дугаар сарын 01-ний өдөр Шилэн дансны тухай хуулийг баталж, 2015 оны 01 дүгээр сарын 01-ээс мөрдөж эхэлсэн.

Шилэн дансны цахим хуудсанд байршуулах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох тухай журмыг Засгийн газрын 2014 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн 384 дүгээр тогтоолоор анх баталж, шилэн дансны цахим сайтад мэдээллийг байршуулж эхэлсэн. 2016 оны эхээр шилэн дансны цахим сайт шинэчлэгдэн өмнөх журмыг хүчингүй болгож, Засгийн газрын 2016 оны 01 дүгээр сарын 11-ний өдрийн 29 дүгээр тогтоолоор журмыг шинэчлэн баталсан байна.

**БҮЛЭГ 1. Шилэн дансны тухай хуулийн 3.1-д заасан байгууллагууд шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд бүрэн хамрагдаагүй байна.**

**1.1 Аймгийн хэмжээнд төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн 98 хувь нь шилэн дансны цахим хуудсанд хамрагдсан байна.**

Дундговь аймгийн хэмжээнд Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1<sup>1</sup>-т заасны дагуу шинэчилсэн шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд улсын төсөвт 27 байгууллага, түүний харьяа 3 сан, орон нутгийн төсөвт болон тусгай зориулалтын шилжүүлгийн 130 байгууллага, 2 нөхөрлөл, 19 ОНӨААТҮГ, нийт 181 байгууллагын шилэн дансны нэгдсэн цахим хуудас бүртгэгдэхээс 179 цахим хуудас нээгджээ. Төрийн болон орон нутгийн өмчит төсвийн байгууллагуудын 98 хувь нь шилэн дансны цахим хуудас нээлгэсэн байна.

### Шилэн дансны цахим хуудас нээлгэсэн судалгаа

Хүснэгт 1

Төсвийн Ерөнхийлөн захирагч	Байгууллагын төрөл	Байгууллагын тоо	Цахим хуудас нээгдсэн	Илүү + дутуу - цахим хуудас
15 сум	ТШЗ	100	100	
	ТЕЗ	15	15	
Аймаг	ТШЗ	14	15	+1
	ТЕЗ	1	1	
Яамдууд	ТШЗ	27	26	-1
	ЗГТС	3	3	
ОНӨҮГ	ААТҮГ	19	19	
БГБХ	Нөхөрлөл	2	0	-2
Нийт		181	179	

Улсын төсөвт 27 байгууллагаас Тагнуулын хэлтэс улсын нууцад хамаарах тул бусад 26 байгууллагууд шилэн дансны цахим хуудсанд бүрэн хамрагдсан.

<sup>1</sup> 3.1.1 төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд

Боржигон мандал, Өлзийт мандал өрхийн эрүүл мэндийн төвүүд /нөхөрлөл/, орон нутгийн өмчит төсвийн байгууллагаас Ахмадын хороо шилэн дансны цахим хуудас тус тус нээлгээгүй байна. Харин ГХБХБГ-ын цахим хуудсыг аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагч болон Газрын харилцаа, барилга хот байгуулалтын сайдын харьяанд давхардуулан нээсэн.

Энэ нь 2016 онд шилэн дансны нэгдсэн цахим хуудас шинэчлэгдэж, байгууллагын админ хэрэглэгч ТЕЗ-ийн багцад хамаарах байгууллагын судалгааг бүрэн гаргаж, нээгээгүйтэй холбоотой бөгөөд, Засгийн газрын 29 дүгээр тогтоолоор батлагдсан шилэн дансны цахим хуудсанд байршуулах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журмын 7.3<sup>2</sup>-т заасныг хэрэгжүүлээгүй байна.

## **1.2 Төрийн өмчит үйлдвэрийн газрын салбар байгууллагууд төв компанидаа нэгтгэгдэж шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд мэдээлдэг байна.**

Аймгийн хэмжээнд ТӨҮГ, ТӨХК-уудын 9 салбар байгууллага үйл ажиллагаа явуулж байна. Үүнээс Зам тээврийн сайдын харьяа Нисэх буудал, Автотээврийн үндэсний төв, Хүнс хөдөө аж ахуйн яамны харьяа Цөм сүргийн үржлийн төв гэсэн 3 салбар шилэн дансны цахим хуудсанд байгууллагын өөрийн цахим хуудастай, бусад 6 салбар байгууллага тусдаа шилэн дансны цахим хуудасгүй төв компанидаа нэгтгэн мэдээлдэг гэсэн хариуг өмнөх аудитаар ирүүлсэн.

### **Төв компанидаа мэдээллээ нэгтгэн мэдээлдэг салбаруудыг хүснэгтээр харуулбал:** хүснэгт 2

№	Харьяалах дээд шатны байгууллага	Салбар байгууллагын нэр
1	Монголын цахилгаан холбоо ТӨХК	МЦХ ХК-ны Дундговь аймаг дахь Холбооны газар
2	Мэдээлэл холбооны сүлжээ ТӨХК	Мэдээлэл холбооны сүлжээ ТӨХК Дундговь салбар
3	Монгол шуудан ТӨХК	Дундговь аймгийн шуудан үйлчилгээний газар
4	Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ ТӨХК	Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ ТӨХК Говийн бүсийн салбар
5	БЗӨБЦТС ТӨХК	БЗӨБЦТС ТӨХК-ний Дундговь цахилгаан түгээх сүлжээ салбар
6	Монгол банк	Дундговь Монгол банк

Орон нутагт салбартай төрийн өмчит үйлдвэрийн газар болон хувьцаат компаниуд нь шилэн дансны цахим хуудсанд салбар байгууллага тус бүрээр эсвэл, нэгтгэж мэдээлэх эсэх талаар Шилэн дансны тухай хуулинд тодорхой заагаагүй. Иймд энэ асуудлыг цаашид журмаар зохицуулан тодорхой болгох талаар өмнөх аудитаар ҮАГ-т санал хүргүүлсэн.

## **1.4 Улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт, төсөл хөтөлбөр, арга хэмжээ, ажил үйлчилгээ гүйцэтгэж байгаа аж ахуйн нэгж, байгууллагыг шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд бүртгээгүй байна.**

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.4-т улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт, төсөл хөтөлбөр, арга хэмжээ, ажил үйлчилгээ гүйцэтгэж байгаа аж ахуйн

<sup>2</sup> 7.3 байгууллагын админ хэрэглэгч дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

7.3.1 байгууллагын анкет болон байгууллагын админ хэрэглэгчийн хувийн мэдээллийг бөглөх

7.3.2 байгууллагын мэдээлэл оруулах хэрэглэгчид болон дотоод аудитын хэрэглэгч үүсгэх

7.3.3 байгууллагын данс нэмэх хүсэлтийг нэгдсэн админд илгээх

нэгж, байгууллага хамрагдахаар хуульчилсан боловч нэгдсэн цахим хуудсанд бүртгэлгүй тул хуулийн энэ заалт хэрэгжихгүй байна.

Аймгийн хэмжээнд 2016 оны 10 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар Шилэн дансны тухай хуулийн 3.1.4 дэх *улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр хөрөнгө оруулалт, төсөл, хөтөлбөр, арга хэмжээ, ажил, үйлчилгээ гүйцэтгэж байгаа аж ахуйн нэгж, байгууллага;/* заалтад хамаарах нийт 5,433.7 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 22 тендерт 17 компани шалгарч, нийт 2,421.9 сая төгрөгийн санхүүжилт авсан. Аймгийн ТЭЗ-ийн цахим хуудсанд оруулсан гүйцэтгэгчийн талаарх мэдээллийг тендерийн судалгаатай тулган шалгахад зөрүү гараагүй.

### **1.5 Төрийн чиг үүрэгт хамаарах ажил, үйлчилгээг хууль тогтоомж, гэрээний үндсэн дээр гүйцэтгэгч байгууллагыг шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд бүртгээгүй байна.**

Ахмад настны нийгмийн хамгааллын тухай хуулийн 9.3<sup>3</sup>-т заасны дагуу 2016 онд аймгийн Засаг дарга Дундговь аймгийн Чөлөөт ахмадын холбоотой гэрээ байгуулж эхний 2 сарын санхүүжилт 6.2 сая, аймгийн Ахмадын хороонд 7.0 сая төгрөгийг тус тус олгосон боловч шилэн дансны нэгдсэн цахим хуудсыг дээрх 2 байгууллага нээлгээгүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 3.1.5<sup>4</sup> дахь заалт, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан журмын 1.3<sup>5</sup> -т заасныг зөрчиж байна. Иймд төрийн чиг үүрэгт хамаарах ажил, үйлчилгээг хууль тогтоомж, гэрээний үндсэн дээр гүйцэтгэгч байгууллагатай гэрээ хийх эрх бүхий этгээд нь авсан санхүүжилтийг шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд мэдээллэх, энэ тухай гэрээний нөхцөлд оруулах талаар журамд тусгах шаардлагатай байна.

**БҮЛЭГ 2. Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг 3.1-д заасан байгууллагууд 89 хувьтай мэдээлсэн байна.**

### **2.1 Төсвийн байгууллагууд тогтмол мэдээлэх мэдээг 92 хувьтай мэдээлжээ.**

Аудитаар Шилэн дансны тухай хуулийн 3.1.1<sup>6</sup>, 3.1.2<sup>7</sup>-т заасан нийт 189 байгууллагаас 164 байгууллагын мэдээллийг 3 дугаар улирлын байдлаар шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд байршуулсан мэдээлэл, байгууллагын админы улирал бүр илгээсэн тайлан, НББ-ийн журнал, холбогдох мэдээ, баримттай тулган шалгалаа. /Тагнуулын хэлтэс, Ахмадын хороо, Боржигон мандал, Өлзийт мандал өрхийн эрүүл мэндийн төвүүд, 15 сумын ЭЭС, ТӨҮГ болон ТӨХК-ийн 6 салбар аудитад хамрагдаагүй/

Аудитаар дараах зөрчлүүд илэрсэн. Үүнд:

- Дундговь аймгийн Цөм сүргийн үржлийн төв 2015, 2016 онд огт мэдээлэл байршуулаагүй,

<sup>3</sup> Энэ хуульд заасан төрийн болон нутгийн захиргааны байгууллагын зарим чиг үүргийг ахмад настны төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлж, төсөл, арга хэмжээний зардлыг санхүүжүүлж болно.

<sup>4</sup> Төрийн чиг үүрэгт хамаарах ажил, үйлчилгээг хууль тогтоомж, гэрээний үндсэн дээр гүйцэтгэгч байгууллага

<sup>5</sup> Байгууллага нь мэдээллийг тогтмол шинэчилж, өөрчлөлт орсон тухай бүр өмнөх мэдээллийг цахим хуудасны архивт хадгалан, архивын мэдээллийн санд нэвтрэх, татаж авах, хэвлэх боломжийг хангасан байна

<sup>6</sup> 3.1.1 төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд

<sup>7</sup> 3.1.2 төрийн өмчит үйлдвэрийн газар



- Цагаандэлгэр сумын ЗДТГ нь тус хуулийн 6.1.2 дахь заалтын дагуу 9 болон 10 дугаар сарын төсвийн гүйцэтгэлийн мэдээг “МЭДЭЭЛЭЛ БАЙХГҮЙ” гэж тэмдэглэсэн боловч тухайн саруудад 31.5 сая төгрөгийн гүйлгээ хийгдсэнийг цахим хуудсанд мэдээлээгүй.
- Дундговь аймгийн ТЕЗ-ийн орон нутгийн төсөвт 113 */тусгай зориулалтын шилжүүлгийн/* байгууллагаас аймгийн ИТХ-аас бусад 112 байгууллага нь Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын 8.1 дэх заалтын дагуу 2016 оны 3 дугаар улирлын байдлаар мэдээллээ байршуулсан боловч илгээгүй зөрчил илэрснийг аудитын явцад залруулан нөхөн мэдээлсэн.

Энэ нь ТЕЗ-ийн дотоод аудитын алба журмын хэрэгжилтэд хяналт тавихгүй байгаатай холбоотой байна.

Цаашид Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын 8.1 дэх */Шилэн дансанд мэдээлэл тавьсан албан тушаалтан, тухайн асуудал хариуцсан нэгж нь байршуулсан мэдээллээ улирал бүр төсвийн ерөнхийлөн захирагчийн дотоод аудитын албанд дараа сарын 15-ны дотор тайлагнана/* заалтын хэрэгжилтэд ТЕЗ-ийн дотоод аудитын алба нь хяналт тавьж ажиллах шаардлагатай.

Аудитын явцад зөрчлийг арилгуулахаар хугацаатай албан шаардлагыг дээрх байгууллагуудад хүргүүллээ.

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1<sup>8</sup> -д заасан мэдээллүүд нь байгууллагын бүтэц, зохион байгуулалтаас шалтгаалан шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд оруулах цэсүүд нь ялгаатай байна.

Үүнийг харьцуулан хүснэгтээр харуулав. /Хүснэгт 3/

#### Тогтмол мэдээлэх цэсийн тоо

хүснэгт 3

Мэдээлэл оруулах давтамж	ТШЗ /цэсийн тоо/	Сан /цэсийн тоо/	ОНӨҮГ /цэсийн тоо/	ТӨҮГ /цэсийн тоо/	ТЕЗ /цэсийн тоо/
Сар бүр	2	2	2	2	5
<b>/10-р сарын байдлаар/ нийт</b>	<b>20</b>	<b>20</b>	<b>20</b>	<b>20</b>	<b>50</b>
Жилд нэг удаа	1	1	1	1	1
<b>Бүгд</b>	<b>21</b>	<b>21</b>	<b>21</b>	<b>21</b>	<b>51</b>

Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд улс, орон нутгийн өмчит төсвийн байгууллага, ОНӨААТҮГ, ТӨҮГ –ууд 3-р улирлын байдлаар сар бүр /тухай бүр/ мэдээлэх 11, жилд нэг удаа

<sup>8</sup> 6.1.1.тухайн жилийн төсөв, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, орон нутгийн хөгжлийн сангийн төлөвлөлтийг жил бүрийн 01 дүгээр сарын 10-ны өдрийн дотор

6.1.2.хагас жилийн төсвийн гүйцэтгэлийг жил бүрийн 08 дугаар сарын 15-ны өдрийн дотор, өмнөх оны төсвийн гүйцэтгэлийг жил бүрийн 04 дүгээр сарын 25-ны өдрийн дотор, сар, улирлын гүйцэтгэлийг дараа сарын 08-ны өдрийн дотор;

6.1.6.төсвийн хэмнэлт, хэтрэлт, түүний шалтгааны тайлбарыг улирал бүр.

мэдээлэх 1 цэс нийт давхардсан тоогоор 102 цэсэнд нийт 3,423 мэдээлэл оруулахаас 89.1 хувь буюу нийт 3,051 мэдээллийг байршуулсан.

Үүнээс 93.2 хувь буюу 2,845 мэдээллийг хуулийн хугацаанд, 6.8 хувь буюу 206 мэдээллийг хугацаа хоцорч мэдээлсэн байна.

Аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газруудын хувьд /төсвийн байгууллагыг бодвол/ сар бүр гүйцэтгэлийн мэдээ тайлан гаргадаггүй, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.4<sup>9</sup>, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.2.<sup>10</sup> –т заасны дагуу зөвхөн улирал, хагас, бүтэн жилээр тайлан гаргаж байна. Иймд шилэн дансны нэгдсэн цахим хуудасны цэсийг байгууллагын онцлогт тохируулан, хуульд заасан тайлан гаргах хугацаатай уялдуулан өөрчлөх шаардлагатай.

## **2.2 Төсөвт байгууллагууд долоо хоног бүр байршуулах мэдээг 98 хувьтай мэдээлсэн байна.**

Шилэн дансны тухай хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллагууд долоо хоногийн дотор байршуулах нийт 2541 мэдээллээс 97.7 хувь буюу 2483 мэдээллийг тогтсон хугацаанд, 2.3 хувь буюу 58 мэдээллийг аудитын явцад нөхөж оруулсан.

Төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэрийг долоо хоногийн дотор 69 байгууллагын 792 тушаалаар 3,140.5 сая төгрөгийг зарцуулсан шийдвэрийг мэдээлсэн. Харин 11 байгууллагын 37 тушаалаар 113.0 сая төгрөгийг зарцуулсан шийдвэрийг мэдээлээгүй байсныг аудитын явцад нөхөн мэдээлсэн.

- Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаягийн мэдээллийг 146 байгууллага нийт 5,124.0 сая төгрөгийн худалдан авалтыг мэдээлсэн, 3 байгууллага 129.5 сая төгрөгийн худалдан авалтыг мэдээлээгүй байсныг аудитын явцад нөхөн мэдээлсэн.
- Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг 59 байгууллагын 756 гүйлгээгээр гарсан 16,194.6 сая төгрөгийн зарлагын гүйлгээг шилэн дансны цахим хуудсаар мэдээлсэн, 14 байгууллагын 24 гүйлгээгээр гарсан 256,0 сая төгрөгийн гүйлгээг мэдээлээгүй байсныг нөхөн мэдээлсэн.
- Таван сая төгрөгөөс дээш гарч байгаа зардлын гүйлгээний ихэнхийг түлш халаалтын зардал болон сум хөгжүүлэх сангаас олгосон зээлийн гүйлгээ эзэлж байна.

Харин 22 байгууллагын 302 гүйлгээгээр 5,900.0 сая төгрөгийн орлого мэдээлсний ихэнх буюу 88 хувийг нийгмийн даатгал, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан, халамжийн сангуудын орлогууд эзэлж байна.

- Байгууллагын батлагдсан орон тоонд орсон өөрчлөлтийг 146 байгууллага 1460 удаа мэдээлэхээс 96 хувь буюу 1401 удаа мэдээлсэн байна. Үүний 128 нь хугацаа хоцорч мэдээлэгдсэн нь байгууллагууд оны эхнээс батлагдсан бүтэц орон тооны талаар “өөрчлөлт ороогүй” гэж мэдээлснийг аудитын явцад Шилэн дансны тухай хуулийн 4<sup>11</sup> дүгээр зүйлийн дагуу оны эхнээс маягтын дагуу нөхөн засуулсантай холбоотой.

<sup>9</sup> Албан татвар төлөгч энэ хуулийн 21.3-т зааснаар хүргүүлсэн хуваарийн дагуу сар бүрийн 25-ны дотор албан татварыг урьдчилан төлж, татвар төлөлтийн улирлын тайланг дараа улирлын эхний сарын 20-ны дотор, жилийн эцсийн тайланг дараа оны 02 дугаар сарын 10-ны дотор харьяалах татварын албанд тушааж, албан татварын жилийн эцсийн тооцоо хийнэ.

<sup>10</sup> Аж ахуйн нэгж, байгууллага улирлын санхүүгийн тайланг дараа улирлын эхний сарын 20, жилийн санхүүгийн тайланг дараа оны 2 дугаар сарын 10-ны өдрийн дотор харилцагч санхүүгийн байгууллагад тушаана.

<sup>11</sup> 4.1.1 мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх

4.1.2 мэдээлэл ойлгомжтой, ач холбогдолтой байх

4.1.3 тогтоосон хугацаанд, тогтмол шуурхай мэдээлдэг байх

- Худалдан авах ажиллагаанд хийсэн аудитын тайлан, дүгнэлт болон бусад хяналт шалгалтын дүнг 164 байгууллага “БАЙХГҮЙ” гэж мэдээлсэн байна.
- Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8, 9 дүгээр зүйлд заасан мэдэгдэл, хөрөнгийн болон урсгал зардалд тусгагдсан арга хэмжээний тендерийн ерөнхий мэдээлэл, тухайн байгууллагын хууль тогтоомжийн дагуу төвлөрүүлэх төлбөр, хураамж, зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээнд орсон өөрчлөлт зэрэг цэсүүдийг ихэнх байгууллага буюу 90 хувь нь “ӨӨРЧЛӨЛТ ОРООГҮЙ” ба “МЭДЭЭЛЭЛ БАЙХГҮЙ” гэж тэмдэглэсэн байна.

Хөдөө сумдын ИТХ, Соёлын төв, Цэцэрлэг зэрэг төсөв багатай байгууллагуудын хувьд сарын гүйцэтгэлийн мэдээ, орон тооны өөрчлөлт, төсөв өмч хөрөнгө захиран зарцуулах гэсэн 2-3 цэст л мэдээлэл байршуулж, бусад цэсийн хувьд мэдээлэл оруулах шаардлага гараагүй байна.

**2.5 Хуулийн 3.1.4, 3.1.5-д заасан этгээд нь 6 дугаар зүйлийн 6.9-д заасны дагуу санхүүжилт болон бусад мэдээллийг, санхүүжилтээ хүлээн авсан төсвийн байгууллагын шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд байршуулсан байна.**

Дундговь аймгийн хэмжээнд 2016 оны 10 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар Шилэн дансны тухай хуулийн 3.1.4 дэх */улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр хөрөнгө оруулалт, төсөл, хөтөлбөр, арга хэмжээ, ажил, үйлчилгээ гүйцэтгэж байгаа аж ахуйн нэгж, байгууллага;/* заалтад хамаарах нийт 5,433.7 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 22 тендерт 17 компани шалгарч нийт 2,421.9 сая төгрөгийн санхүүжилтийг олгосон. Мөн хуулийн 3.1.5 дахь */төрийн чиг үүрэгт хамаарах ажил, үйлчилгээг хууль тогтоомж, гэрээний үндсэн дээр гүйцэтгэгч./* заалтад хамаарах 15 сумын Мал эмнэлэг, Чөлөөт ахмадын холбоо, аймгийн Ахмадын хороо зэрэг байгууллагад нийт 265.3 сая төгрөгийн санхүүжилт олгосныг журмын дагуу Аймгийн ТЕЗ-ийн шилэн дансны цахим хуудсанд мэдээлжээ.

**БҮЛЭГ 3. Шилэн дансны тухай хуулийн 8.1, 8.2-т заасан этгээд шилэн дансны хяналтыг бүрэн хэрэгжүүлээгүй байна.**

**3.1 Шилэн дансны үйл ажиллагаанд тавих хөндлөнгийн хяналтыг бүх шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, иргэдийн Нийтийн Хурал хяналт тавихгүй байна.**

Шилэн дансны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1-д */энэ хуулийн 3.1-д заасан этгээдийн шилэн дансны үйл ажиллагаанд тавих хөндлөнгийн хяналтыг бүх шатны иргэдийн Төлөөлөгчдийн хурал, иргэдийн нийтийн хурал, төрийн аудитын байгууллага хэрэгжүүлнэ/* заасны дагуу аймгийн хэмжээний төрийн болон орон нутгийн өмчит нийт 179 байгууллагын Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд ААГ хяналт тавьж ажиллав. Бүх шатны ИТХ, иргэдийн Нийтийн Хурал хяналт тавихгүй байгаа нь аймгийн ИТХ өмнөх зөвлөмжийг хэрэгжүүлэх талаар ажил зохион байгуулаагүйтэй холбоотой байна.

### 3.2 Санхүүгийн хяналт, аудитын алба шилэн дансны хэрэгжилтэд хяналт тавих нөхцөл бүрдээгүй байна.

Шилэн дансны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2<sup>12</sup>-т заасны дагуу ТЕЗ-ийн Дотоод аудитын алба 2016 оны 3 дугаар улирлын байдлаар шилэн дансны үйл ажиллагаанд хяналт шалгалтыг 2016 оны 11 сарын 02-ны өдрөөс эхлэн 12 сарын 01 өдөр хүртэлх хугацаанд нийт 151 байгууллагыг хамруулан гүйцэтгэсэн байна.

Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын 8.1 дэх *“Шилэн дансанд мэдээлэл тавьсан албан тушаалтан, тухайн асуудал хариуцсан нэгж нь байршуулсан мэдээллээ улирал бүр төсвийн ерөнхийлөн захирагчийн дотоод аудитын албанд дараа сарын 15-ны дотор тайлагнана/* заалтын дагуу ТЕЗ-ийн дотоод аудитын алба улирал бүр хяналт тавьж ажиллах нөхцөл бүрдээгүй байна. Энэ нь цахим сүлжээнд нэвтрэх нууц үгийг тус албанд олгоогүй, аймгийн Санхүү төрийн сангийн хэлтсийн дотоод хяналт хариуцсан мэргэжилтэн хариуцаж байгаатай холбоотой байна.

### 3.3 Өмнөх аудитаар өгөгдсөн зөвлөмж, албан шаардлагын хэрэгжилт 90 хувьтай байна.

Өмнөх аудитаар 3 заалт бүхий зөвлөмжийг холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлсэн. Шилэн дансны нэгдсэн цахим хуудас шинэчлэгдсэн тул 2016 оны 01 сарын 25-ны дотор 2015 оны шилэн дансны мэдээллийг нөхөн оруулж, аймгийн Санхүү, төрийн сангийн хэлтсээс бүх төсвийн болон сумдын нягтлан бодогч нарт сургалт зохион байгуулжээ.

Сургалтаар:

1. Шинэчлэгдсэн шилэн дансны цахим хуудасны талаарх танилцуулга
2. Шинэчлэн баталсан Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ыг танилуулга
3. байгууллагын админ эрх, шинээр эрх үүсгэх, эрхийг хязгаарлах, ажил чиг үүргийг хуваарилах чиглэлээр сургалт хийжээ.

Дэрэн сумын “Эрдэм шинжилгээ туршилт үйлчилгээний төв” ОНӨААТҮГ Аудитын газраас өмнөх аудитаар өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлээгүй байна.

## Аудитын дүгнэлт

Аудитын явцад цуглуулсан нотлох баримт, аудитын дүнд тулгуурлан дараах дүгнэлтийг хийж байна.

1. Шилэн дансны тухай хуулийн 3.1-д заасан байгууллагууд шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд бүрэн хамрагдаагүй байна.
2. Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг 3.1-д заасан байгууллагууд 89 хувьтай мэдээлсэн байна.
3. Аймаг, сумдын ИТХ, иргэдийн Нийтийн Хурал хуулинд заасан хяналтын үүргээ бүрэн хэрэгжүүлээгүй байна.

<sup>12</sup> энэхүү хуулийн 3.1.1-д заасан төсвийн байгууллага, албан тушаалтаны шилэн дансны үйл ажиллагаанд тавих дотоод хяналтыг Төсвийн тухай хуулийн 69-р зүйлд заасны дагуу төсвийн ерөнхийлөн захирагч хэрэгжүүлнэ

## Аудитын зөвлөмж

### **Аймаг, сумдын Засаг дарга нарт**

1. Шилэн дансны тухай хуулийн 8.2-т заасны дагуу хяналтыг хэрэгжүүлж ажиллах

### **Аймаг сумдын иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд**

1. Аймаг, сумын ИТХ, иргэдийн Нийтийн Хурал хуулинд заасан хяналтыг бүрэн хэрэгжүүлэхэд анхаарч ажиллах,

Тайлан бичсэн:

Ахлах шинжээч

Д.Ихбаяр

Аудитор

Х.Гарам



## ДЭЭД ШАТНЫ БАЙГУУЛЛАГАД ХҮРГЭХ САНАЛ

ҮАГ-аар дамжуулан Сангийн яаманд дараах саналыг хүргүүлж байна. Үүнд:

1. Аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газруудын хувьд тайлан гаргах хугацаа төсөвт байгууллагаас ялгаатай тул шинэчлэгдсэн шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд байгууллагын онцлогт тохируулан цэстэд шинэчлэл өөрчлөлт хийх.
2. Төрийн өмчит аж ахуйн тооцоотой байгууллагын салбар байгууллагууд шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд бие даасан цахим хуудастай байх эсэх талаар журмаар зохицуулж өгөх

**ШАЛГАГДАГЧ БАЙГУУЛЛАГААС ИРҮҮЛСЭН САНАЛ ТАЙЛБАР**

ᠣᠷᠢᠨᠢᠨ ᠠᠵᠠᠭᠠᠨ ᠰᠢᠨᠠᠭᠠᠨ 19 дүгээр зүйлийн 19.3.1-᠔ ᠴᠠᠭᠠᠨ ᠠᠵᠠᠭᠠᠨ ᠠᠵᠠᠭᠠᠨ  
ᠠᠵᠠᠭᠠᠨ ᠠᠵᠠᠭᠠᠨ ᠠᠵᠠᠭᠠᠨ 19 дүгээр зүйлийн 19.3.1-᠔ ᠴᠠᠭᠠᠨ ᠠᠵᠠᠭᠠᠨ ᠠᠵᠠᠭᠠᠨ

Тайлбар 1-г үзнэ үү.	<p style="text-align: center;"><b>ДУНДГОВЬ АЙМГИЙН САНХҮҮГИЙН ХЯНАЛТ, АУДИТЫН АЛБА</b></p> <p style="text-align: center;">48090 Сайнцагаан сум, Дундговь аймаг Утас/Факс: 70-59-36-19</p> <p style="text-align: center;">2016.12.13 № 62 танай 2016.12.09-ны № 2/1411 -т</p> <p style="text-align: center;">┌ ДУНДГОВЬ АЙМГИЙН АУДИТЫН ┐ ГАЗРЫН ДАРГА Т. ОЮУНЧИМЭГ ТАНАА</p> <p>Аймгийн ЗДТГ-аас ирүүлсэн албан бичигтэй хамт танай байгууллагаас Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт, үр дүнд нийцлийн аудит хийсэн тайлангийн төслийг хүргүүлсэн байна. Засгийн газрын 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын 8 дугаар зүйлийн 8.1-т “Шилэн дансанд мэдээлэл тавьсан албан тушаалтан, тухайн асуудал хариуцсан нэгж нь байршуулсан мэдээллээ улирал бүр төсвийн ерөнхийлөн захирагчийн дотоод аудитын албанд дараа сарын 15-ны дотор тайлагнана” гэж заасан боловч цахим сүлжээнд нэвтрэх нууц код нь СТСХ-ийн дотоод хяналт хариуцсан мэргэжилтэнд /админ/ байдаг тул түүгээрээ хяналтыг тавьж байгаа. Бид 2016 оны төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу 11 дүгээр сарын 02-оос тайлант оны эхний 9 сарын шилэн дансны цахим сүлжээнд байршуулсан мэдээлэлд шалгалт хийж ажлынхаа тайланг танай байгууллагад албан бичгээр хүргүүлсэн болно. Бусад зүйл заалт, зөвлөмжтэй санал нийлж байгааг мэдэгдэе.</p> <p style="text-align: center;">ДАРГА  Г.ЗОРИГТ</p> <p style="text-align: center;"></p>
----------------------------	--

**АУДИТЫН ГАЗРЫН ТАЙЛБАР**

ᠣᠷᠢᠨᠠᠨᠠᠭᠤᠨ ᠠᠨᠠᠭᠤᠨ ᠠᠨᠠᠭᠤᠨ 19 дүгээр зүйлийн 19.3.2-᠔ ᠴᠠᠨᠠᠨᠢ ᠤ ᠠᠠᠶᠢᠰᠤ ᠠᠨᠠᠭᠤᠨ ᠠᠨᠠᠭᠤᠨ ᠠᠨᠠᠭᠤᠨ ᠠᠨᠠᠭᠤᠨ ᠔ᠷᠢᠨᠠᠨᠠᠭᠤᠨ ᠔ᠷᠢᠨᠠᠨᠠᠭᠤᠨ дараах ᠔ᠠᠶᠢᠶᠢᠶᠢᠶᠢᠶᠢ ᠠᠨᠠᠭᠤᠨ байна. Үүнд:

**Аймгийн Засаг даргаас ирүүлсэн санал, тайлбарт өгөх Аудитын газрын тайлбар**

<b>Тайлбар 1</b>	Саналыг хүлээн авч бүлэг 3-ын 2-т ТЕЗ-ийн Дотоод аудитын алба шилэн дансны үйл ажиллагаанд 2016 оны 3 дугаар улирлын байдлаар хяналт шалгалт хийгээгүй, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллаагүй гэснийг Санхүүгийн хяналт, аудитын алба шилэн дансны хэрэгжилтэд хяналт тавих нөхцөл бүрдээгүй байна гэж өөрчлөн найрууллаа.
------------------	--

## ТАЙЛАНГ БАТАЛГААЖУУЛСАН ТУШААЛ


 ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА  
 ДУНДГОВЬ АЙМГИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
 ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН ТУШААЛ

2016 оны 12 сарын 13 өдөр

Дугаар 1/36

Мандалговь

 Нийцлийн аудитын тайланг  
 баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.5, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2014 оны 121 дүгээр тушаал, Гүйцэтгэлийн аудитын журмын 12.40-д заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Үндэсний Аудитын газрын харьяа Дундговь аймгийн Аудитын газрын 2016 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг үндэслэн нэгдсэн төлөвлөгөөгөөр "Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт"-д хийсэн нийцлийн аудитын тайлан /ҮАГ-НАГ/2016/04-НА/ -г баталсугай.

2. Аудитаар илэрсэн зөрчлийн жагсаалт, албан шаардлагыг хавсралтаар баталсугай.

3. "Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт"-д хийсэн нийцлийн аудитын тайланг Үндэсний Аудитын газар болон аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг дарга нарт тус тус хүргүүлсүгэй.

4. Нийцлийн аудитаар аймаг, сумдад илэрсэн зөрлүүдийг арилгаж, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтийг бүрэн хангуулан, үр дүнгийн талаар 2017 оны 01 дүгээр сарын 25- ны дотор Аудитын газарт ирүүлэхийг аймгийн Засаг дарга /О.Бат-Эрдэнэ/-д зөвлөсүгэй.

5. Аудитаар өгөгдсөн зөвлөмж, албан шаардлагын хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг 2017 оны 1 дүгээр улиралд гарган танилцуулахыг аудитын менежер /Х.Наранцацрал/, нийцлийн аудитын багийн ахлах шинжээч /Д.Ихбаяр/ нарт үүрэг болгосугай.

 ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Т.ОЮУНЧИМЭГ


090000007:



## ТАЙЛАНГИЙН ХАВСРАЛТ

## Шилэн дансны хуулийн хэрэгжилтэнд хийсэн аудитаар өгсөн зөрчлийн бүртгэл

## Хавсралт 1

№	Байгууллагын нэр	ТШЗ-ийн нэр	Зөрчлийн товч утга	Дугаар	Зөрчлийн дүн		Төлбөрийн акт, албан шаардлагын	
					А к т	Албан шаардлага	тогтоосон хугацаа	барагдуулах хугацаа
1	Цөм сүргийн үржлийн төв	Ё.Санжаасүрэн	2016 онд Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд мэдээлэл огт байршуулаагүй		-	0	12/7/2016	3/15/2017
2	Эрдэм шинжилгээ туршилт үйлчилгээний төв	М.Сосорбурам	Өмнөх аудитаар өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлээгүй		-	0	12/7/2016	1/25/2017
3	Цагаандэлгэр сумын ЗДТГ	С.Сайнбаяр	9, 10 сарын төсвийн гүйцэтгэлийн мэдээг “Мэдээлэл байхгүй” гэж 31.5 сая төгрөгийн гүйлгээг мэдээлээгүй.			35,900.0	12/7/2016	1/25/2017
	Нийт					35,900.0		